

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр +13
Шөнө +10

УЛС ТӨР

Х.БАТТУЛГА: ОХУ-ТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛНЭ ГЭЖ НАЙДАЖ БАЙНА

V нүүрт

ЦАГ ҮЕ

НИЙГИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХ ЦАХИМ КАРТ ШИНЭЭР АВАХ, СУНГУУЛАХ ОЮУТНУУДЫН ӨРГӨДЛИЙГ АВЧ ЭХЭЛЛЭЭ

VII нүүрт

Дугаарын 60 мөр

Ерөнхийлөгчийн тамгыг баран бариултай болгоё

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудал нэлээд идэвхтэй яригдаж байна. Тэр дундаа Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа улам идэвхжиж эхэллээ. Гэхдээ энэ асуудал араасаа янз бүрийн маргаан дагуулж байгаа. Эрх баригчид Үндсэн хуулийг өөрчлөх эрхтэй, эрхгүй гэх мэтээр. Мөн өөрчлөх гэж байгаа заалтууд нь ч маргаан дагуулж байгаа юм. Тэгвэл зарим эрдэмтэн судлаачид Үндсэн хуульд орсон, түүхэн мэдлэгээ анхаараагүйн улмаас алдаатай болсон заалт байгааг өөрчлөх хэрэгтэй гэсэн санал гаргаж эхэллээ. Тухайлбал, СГЗ, доктор, профессор Г.Норовсамбуу гуай Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн зургадугаар заалтыг өөрчлөх хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлж байгаа юм. Тэр нь Монгол төрийн тамга арслангийн дүрс бүхий барилуулай байна гэсэн утга бүхий заалт юм.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

С.МӨНХЧУЛУУН: ГАРЫН ҮСЭГ ЦУГЛУУЛААД БАЙГАА НЬ ЭРХ МЭДЭЛД ХҮРЭХ ГЭСЭН ТЭМЦЭЛ ГЭЖ ХАРЖ БАЙНА

Н.ПУНЦАГ

НИТХ-ын МАН-ын бүлгийн дарга С.Мөнхчулуунтай цаг үеийн асуудлаар ярилцлаа.

-НИТХ дахь МАН-ын бүлгийн цөөнгүй гишүүд даргыгаа огцруулахаар гарын үсэг цуглуулж, Иргэдийн хуралд хүргүүлчихээд байгаа. Дээрээс нь АН-ын бүлгийн гишүүд ч нэмэгдэж байгаа юм билээ. Тэгэхээр НИТХ-ын дарга огцрох магадлалтай болсон гэж хэлж болох уу?

-НИТХ дахь МАН-ын 16 гишүүн Иргэдийн хурлын даргыг огцруулах тухай хүсэлт гаргаж, гарын үсэг цуглуулсан. Улмаар Иргэдийн хуралд хүргүүлчихээд байна. Мөн өнөөдөр /өчигдөр/ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дахь АН-ын бүлгээс энэ санаачилгыг дэмжиж байна хэмээн мэдэгдэж, хэвлэлийн хурал хийсэн. Уг нь өвөлжилтийн бэлтгэл, хичээлийн шинэ жилийн нээлтээс авахуулаад олон

ажил хаяанд ирчихлээ. Улс оронд хийх ажил их байхад хажуугаар улс төр хийгээд байгаад харамсалтай л байна. НИТХ дахь МАН-ын бүлэг нийтдээ 34 төлөөлөгчтэй. Түүний 16 нь НИТХ-ын дарга Ц.Сандуйг огцруулахаар гарын үсэг зурсан. Энэ нь олонхи болохгүй гэсэн үг. АН-ын бүлгийн 11 төлөөлөгч нэмэгдээд гарын үсэг зурж байгаа юм билээ. Нийлээд 27 төлөөлөгч болсон. Тэгсэн ч Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны хүрээнд Иргэдийн хурлын ээлжит бус хурлыг хуралдуулах хэмжээнд хүрээгүй. Дээрээс нь гарын үсгээ зураагүй МАН-ын төлөөлөгчид 60 тэрбумын хэрэгт холбогдоод байгаа хүмүүсийг өмгөөлж хамгаалж байна гэсэн мэдээллийг хэвлэлээр болон сошиалаар тарааж байна. Тийм юм байхгүй.

Үргэлжлэл нь II нүүрт



ОНЦЛОХ МЭДЭЭ

Ерөнхийлөгч ДАШТ-д оролцох жүдочдын бэлтгэлтэй танилцлаа

Жудо бөхийн насанд хүрэгчдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 28-нд Унгарын нийслэл Будапешт хотноо болох билээ. Манайхаас эрэгтэй, эмэгтэй тус бүр есөн жинд 18 жүдоч оролцохоор "Говь ресорт" цогцолборт бэлтгэлээ базааж байгаа юм. Тэгвэл өнгөрсөн ням гарагт Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга дэлхийн аваргад оролцохоор бэлтгэлээ базааж байгаа жүдочдын бэлтгэлтэй танилцлаа. Мөн хамт бэлтгэл хийж, тамирчдынхаа бэлтгэлийг шалгасан юм. Дашрамд дурьдахад, манай улсаас энэ удаагийн дэлхийн аваргад +100 кг-ийн жинд Олимпын аварга Н.Түвшинбаяр оролцох нь анхаарал татаж байгаа билээ.



ДЭЛХИЙ

ПХЕНЬЯН: Гал дээр тос нэмлээ



Б.ДАВАА

Солонгосын хойгт хурцадмал байдал үүссэн энэ үед АНУ-БНСУ-ын уламжлалт хамтарсан цэргийн сургуулилт эхэллээ.

Сургуулилт өчигдөр эхэлсэн бөгөөд 11 хоногийн турш үргэлжлэх юм байна. АНУ, БНСУ-ын цэргийн хамтарсан сургуулилт Солонгосын хойгт жил бүр

зохион байгуулагддаг юм. Хойд Солонгосын зүгээс тус сургуулилыг удаа дараа эсэргүүцэн баллистик пуужин харваж, сануулга өгдөг байв. Гэвч, нөхцөл байдал хурцадсан энэ үед "Ulchi-Freedom Guardian" сургуулилыг хийж буй нь бүс нутагт болгоомжлол үүсгэж байна. Энэ жилийн сургуулилтад БНСУ-аас 50 мянга, АНУ-аас 17500 цэргийн алба хаагч оролцож байгаа аж. Энэ нь өнгөрсөн жилийнхтэй харьцуулахад 7500-аар багассан үзүүлэлт юм байна. Өмнө нь АНУ-ын 25 мянган цэргийн алба хаагч тус сургуулилтад оролцож байжээ.

Үргэлжлэл нь VI нүүрт

FINE MECHANICAL WATCHMAKING, FROM JAPAN.

PRESAGE

TRIMATIC

Trimatic symbolizes three Seiko inventions that ensure the highest levels of reliability and durability in its mechanical watches.

SEIKO

SEIKO BOUTIQUE - 1	Наран Плаза, 4-р давхар, Чингисийн өргөн чөлөө-29	Утас: 99926756
SEIKO BOUTIQUE - 2	Наран Молл, 2-р давхар, Сүүлийн гудамж -42/1	Утас: 88099991
SEIKO SHOP - 1	Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж - 9	Утас: 11-326435
SEIKO SHOP - 2	Наран Центр, УИД-ын баруун талд, Энхтайвны өргөн чөлөө	Утас: 88039397

ХААН банк					Хугалгаа хөгжлийн банк						
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2438.00	2452.00	ФУНТ	3100.00	3177.00	АМ.ДОЛЛАР	2438.00	2452.00	ФУНТ	3107.00	3183.00
ЕВРО	2836.00	2897.00	РУБЛЬ	40.40	42.40	ЕВРО	2846.00	2906.00	РУБЛЬ	40.45	42.93
ИЕН	22.20	22.57	ЮАНЬ	364.00	367.50	ИЕН	22.06	22.66	ЮАНЬ	364.00	367.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

БАЙР СУУРЬ

С.МӨНХЧУЛУУН: ГАРЫН ҮСЭГ ЦУГЛУУЛААД ХҮРЭХ ГЭСЭН ТЭМЦЭЛ ГЭЖ



Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

МАН-ын бүлэг гэдэг бол өөрөө намын дүрэмд байдаг нэг бүтэц. Бид Нийслэлийн МАН-ыг төлөөлж энд сууж байгаа. Нийслэлийн МАН-ын тэргүүлэгчид хуралдаж, ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна. Нөгөө талаар өнгөрсөн долоо хоногт МАН-ын Удирдах зөвлөл хуралдсан. Намын Удирдах зөвлөл хуралдаад, өнгөрсөн

Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор ямар нэгэн албан тушаалтанд хариуцлага тооцохгүй гэж шийдвэр гаргасан. Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой хариуцлагын асуудлыг МАН-ын Их хурлаар ярина. Их хурал есдүгээр сард хуралдана. Ердөө л 20 орчим хоногийн дараа хурал болох гэж байхад наана нь улстөржиж, намыг хагалан бутаргаж, гэрээ хэлэлцээнийг цалгардуулах, тогтворгүй

байдал үүсгэх хэрэггүй байгаа юм. 27 төлөөлөгч гарын үсэг зурсан, Иргэдийн хурлын даргыг огцруулна гэж АН-ын гишүүдийн 30 нь буюу гуравны гээд Иргэдийн хурлыг даргыг огцруулж болохгүй гэдгийг би хэлэх гэж дахин сануулаад байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бол орон нутгийн байгууллагуудын мөрдөх ёстой Үндсэн хууль л гэсэн үг. Бид энэ хуулийг л

барьж ажилладаг. Энэ хуулинд Иргэдийн хурлын даргыг гарын үсэг цуглуулаад огцруулна гэсэн заалт байхгүй. НИТХ-ын гишүүдийн 30 нь буюу гуравны хоёроос дээш төлөөлөгч гарын үсэг зурсан бол ээлжит бус хурлыг хуралдуулна гэсэн заалт бий. Мөн нийт төлөөлөгчдийн гуравны хоёроос дээш гишүүн санал гаргавал хурал тарна гэсэн заалт байгаа. Төлөөлөгч нар гарын үсэг цуглуулаад, Иргэдийн хурлын даргыг

огцруулах боломжгүй гэдгийг тэд бүгдээрээ мэднэ. Тэгсэн мөртлөө улс төрийн зорилготой үйлдлүүдийг хийж байгаа нь харамсалтай байна. Өнөөдөр бид улс төр хийх гэж энд ажиллаагүй. Нийслэлийн сая гаруй иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлэх л гэж ажиллаж байгаа. Аль аль намын бүлэг нь тийм зорилготой ажиллаж байгаа гэж би боддог. Одоо улстөржилтөө зогсоож, өвлийн бэлтгэл, сургууль, цэцэрлэгийн нээлт гээд ажлууддаа анхаарлаа хандуулмаар байна. Дээрээс нь би бүлгийн даргын хувьд төлөөлөгчиддөө хандаж хэлье. Нэгэнт бид намын дүрэмтэй. Дүрэм бол намын гишүүддээ Үндсэн хууль мэт байх ёстой. Намын нэрээр өрсөлдсөн, сонгогдсон, албан тушаалд томилогдсон. Тийм болохоор намын дүрмийнхээ хүрээнд ажиллаач гэж хэлье. Бага хурал, Их хурал ирэх сард болно. Түүнээс өмнө улстөржөөд яах юм бэ л гэж хүсмээр байна.

Хуулийн дагуу огцруулах боломжгүй юм байна. Гэхдээ ёс зүйн хүрээнд огцруулах, огцрох асуудал байж болно биз дээ. Иргэд бол шударга ёсыг л шаардаад байгаа шүү дээ?

Хуульд Иргэдийн хурлын даргыг огцруулах заалт байхгүй гэдгийг түрүүнд хэлсэн. Харин хууль зөрчсөн гэдэг нь шүүхээр тогтоогдох юм бол хариуцлагын асуудлыг нам дотроо ярьж болно. Ер нь бол өнөөдрийг хүртэлх хугацаанд Иргэдийн хурлын даргыг огцруулж байсан түүх байхгүй. Яагаад гэвэл хуульд

тийм заалт байдаггүй учраас. Зөвхөн Иргэдийн хурлын дарга хүсэлтээрээ огцорч болно. Энэ намын дүрэм журмын хүрээнд шийдэгдэх асуудал. Түүнээс биш 30 төлөөлөгч гарын үсэг зурлаа ч энэ асуудал шийдэгдэхгүй. 27 төлөөлөгч гарын үсэг зураад өгчихлөө гээд ээлжит хурал ч хуралдахгүй. Ээлжит хурлыг хийх эсэхээр тэргүүлэгчид хуралдах ёстой. Тэргүүлэгчид хуралдсаны дараа ээлжит хурлыг хуралдуулах эсэх шийдвэрээ гаргадаг. Гэх мэт шат дараатай, дүрэм журамтай юм.

-МАН одоогийн байдлаар хоёр хуваагдчихаад байна. Их хуралдаа ч, нийслэлдээ ч тэр. Нэг хэсэг нь намын нэр хүнд уналаа, шинэчлэх цаг болсон хэмээн ярьж, зарим хүмүүст хариуцлага тооцье гээд байгаа. Энэ асуудалд та ямар байр сууринаас хандаж байна?

Өнгөрсөн хоёр жилд улс төрийн хэд хэдэн сонгууль боллоо. Үүнтэй холбоотойгоор, улс төрийн зорилготой янз бүрийн асуудал гаргаж ирж байж ч болох. Тэр яригдаад байгаа зүйлс багтай үнэн үү гэдэг нь хууль, шүүхийн байгууллагаар тогтоогдоогүй байхад бид тал талд янз бүрээр ярих боломжгүй. Бид ийм байр суурьтай л байгаа. Түүнээс биш намын нэр хүнд уналаа, сэргээх хэрэгтэй гэдэг нь одоо яригдаад байгаа зүйлсээс болов уу. Эсвэл зохион байгуулалттайгаар, манай намын нэр хүндийг унагаахаар оролдож байна уу гэдэг нь бас сонин байна. Өнөөдөр хэсэг бүлэг хүмүүс

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



С.Бямбацогт сайд Дархан-Уул аймагт ажиллав

ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт, ХЗДХЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтгийн газрын дарга Э.Эрдэнэсүрэн, Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Я.Жавхлан, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Л.Уянга, хэвлэлийн ажилтан Ц.Оюунтунгалаг нарын бүрэлдэхүүнтэй баг өнгөрсөн пүрэв, баасан гарагт Дархан-Уул аймаг дахь хууль зүй, дотоод хэргийн салбарын харьяа байгууллагын үйл ажиллагаанд танилцаж, ажилтан албан хаагчидтай уулзалт хийлээ. Уулзалтын зорилго нь аль нэг байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, хянаж шалгах биш салбарын бодлого, хууль тогтоомж анхан шатны нэгж дээр хэрхэн хэрэгжиж байгаагаар танилцах, хуулийг хэрэгжүүлж өдөр тутам иргэдтэй харилцаж байгаа ажилтан, алба хаагчдаас санал, сэтгэгдлийг нь сонсох, тэдний өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд оршиж байгааг С.Бямбацогт сайд онцолсон юм. Тус аймаг хүн амын тоогоор нийслэлийн гурван дүүрэгтэй тэнцүү бөгөөд олон улсын болон дотоодын иргэд, тээврийн хэрэгслийн урсгал тасардаггүй тул Дархан-Уул аймаг дахь хууль зүй, дотоод хэргийн салбарын харьяа байгууллагууд нэлээд

ачаалалтай ажиллаж байгааг уулзалтын үеэр холбогдох албаны хүмүүс хэллээ. Хамгийн түрүүнд тус аймгийн Цагдаагийн газрын үйл ажиллагаатай танилцлаа. Тус газрын хувьд эрүүлжүүлэх байрны барилга нь стандартын шаардлага хангахгүй, хүний эрх зөрчиж байгаа талаар Хүний эрхийн комиссоос зөвлөмж, аймгийн прокурорын газраас удаа дараа шаардлага ирүүлснийг удирдлагууд нь дуулгасан. Тиймээс эрүүлжүүлэх байрны барилгын өргөтгөл, шинэчлэн засварлах шаардлагатай байгааг учирлаж байв. Хэдийгээр байрны асуудал байгаа ч өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байгаа бөгөөд энэ оны эхний хагас жилд гэмт хэрэг 3.3 хувиар буурсан, илрүүлэлт 1.9 хувиар өссөн үзүүлэлттэй байгааг эсэргэцээнд чимэгтэй мэдээ дуулгалаа. Энэ нь цагдаагийн ажилтан албан хаагчдын шаргуу хөдөлмөрөөс гадна хяналтын камерын ач тус гэдгийг удирдлагууд нь хэлж байлаа. Дараа нь Дарханы Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, түүний харьяа хорих 445 дугаар ангийн нөхцөл байдалтай танилцав. Сүүлийн жилүүдэд хорих ангийн нөхцөл байдал эрс сайжирч, хүмүүжигчид анги дотроо үйлдвэрлэл эрхлэх, сургалтад хамрагдах боломж нээгдсэн

байна. Хүмүүжигчдийг ажлын байраар ханган ажиллахын зэрэгцээ мужаан цех, арьс ширэн урлал, гар урлал, эсгий үйлдвэрлэлийн чиглэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бэлэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж байгаа аж. Дархан-Уул аймагт ажилласан багийн дараагийн уулзалт тус аймгийн Шүүхийн шинжилгээний албанд өрнөлөө.

Энэ байгууллага хоёр шинжээч эмчтэй ч бусад аймагтай харьцуулахад гурав дахин их ачаалалтай ажилладаг. Жилдээ дунджаар 1200 шүүх эмнэлгийн шинжилгээ хийдэг гэдгийг удирдлагууд нь дуулгав. Тиймээс эмчийн орон тоо, унааны асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсч байсан юм. ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт болон дагалдан яваа албаныхан Дарханы Улсын бүртгэл болон Архивын хэлтсийн үйл ажиллагаатай ч энэ үеэр танилцав. Уулзалтын төгсгөлд ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт Дархан-Уул аймаг дахь салбарынхаа алба хаагчидтай нэгдсэн уулзалт зохион байгууллаа. Салбарын сайд нь Дархан-Уул аймагт ажиллаж, харьяа агентлаг байгууллагынхаа нөхцөл байдалтай газар дээр нь танилцаад, санал сэтгэгдлийг сонсож байгаад жирийн албан хаагчид сэтгэгдэл өндөр байлаа.

Ц.Баатархүү: Энэ сарын 31-нд болох НИТХ-аар Ц.Сандуйг огцруулах асуудлыг хэлэлцэнэ

НИТХ дахь Ардчилсан намын бүлгээс өчигдөр “60 тэрбум”-ын асуудалд нэр холбогдоод байгаа НИТХ-ын дарга Ц.Сандуйг огцруулах талаар мэдэгдэл хийлээ. Энэ үеэр НИТХ дахь АН бүлгийн дарга Ц.Баатархүү “Төрийн албыг наймаалцаж, 60 тэрбум төгрөг босгох МАН-ын удирдлагуудын хэрээс хэтэрсэн үйлдэл үнэн бодит болохыг тус намын Ерөнхий нарийн бичгийн даргаас эхлээд жирийн гишүүд нь өөрсдөө хүлээн зөвшөөрсөн. Энэхүү “60 тэрбум”-ын гэх үйлдэл нь төрийн албаны чадавхийг бууруулсан, чадварлаг төрийн албан хаагчийн эрхийг ноцтой зөрчсөн, албан тушаал эрх мэдлийн арилжааг хохуулэн

дэмжсэн, ёс зүйгүй үйлдэл байтал эрх баригч намын удирдах намын зөвлөл нэр бүхий албан тушаалтнууддаа хариуцлага тооцох биш, хаацайлж, хамгаалах оролдлого хийсээр байгаа нь олон нийтийн зэвүүцлийг төрүүлсээр байгаа юм. Иймд НИТХ дахь АН-ын бүлгээс НИТХ-аар НИТХ-ын даргыг огцруулах асуудлыг хэлэлцэх ёстой гэж үзэж байна. Одоогоор НИТХ дахь МАН-ын 16 төлөөлөгч, АН-ын 11 төлөөлөгч нийт 27 төлөөлөгч Ц.Сандуйг огцруулах асуудлыг НИТХ-аар хэлэлцүүлэхийг дэмжсэн. Иймээс энэ сарын 31-нд болох НИТХ-аар уг асуудлыг хэлэлцэнэ” гэсэн юм.



О.Баасанхүү: Тэтгэврийнхнийг гайтай, өөтэй гэж гадуурхаж, жийдэг ч юм биш шүү

Цахим гүлжээнд цаг наргүй байр сууриа илэрхийлж байдаг гишүүдийн нэг бол МАХН-аар овоглогддог УИХ-ын гишүүн О.Баасанхүү. Тэрбээр байнгын хорооны хурал, чуулганы хурал дээрээс ч лайв хийж, ёстой л тойргийнхоо ард түмэнтэй тувт хамт байж, эрхэм гишүүдийн үнэн төрхийг илчилдэг гэхэд хилсдэхгүй. Тэгвэл ганц дайчин ганцаардахгүй гэсэн уриатай эрхэм гишүүн цахим хуудсаараа дамжуулан цаашид ч мэдээлэл хийж байхаар болсон гэнэ шүү. Тодруулбал, тэрбээр өчигдөр ХНХ-ын сайд Н.Номтойбаярыг ажлаа хийхийг хүсчээ. О.Баасанхүү “Н.Номтойбаяр хэвлэлээр У.Хүрэлсүхийг тэтгэвэртэй гар гэсэн байна билээ. Гавьяа байгуулсан хүн л гавьяагаа эдлэх гэж тэтгэвэрт гардаг. Бидний аав, ээжүүд Монгол Улсад асар их бүтээн байгуулалт хийчихээд гавьяаныхаа амралтыг эдлэх гэж тэтгэвэрт гардаг. Түүнээс гайтай, өөтэй гэж гадуурхаж, жийддэг ч юм биш. Тэтгэврийн насныхныг дорд үздэг Хөдөлмөрийн сайдтай байгаадаа харамсаж байна. Номтойбаяр аа, миний дүү болчимгүй зүйл ярих хэрэггүй шүү, тэтгэвэр насныхныг юу гэж боддог чинь харагдаж байна, болиорой” хэмээн ахын ёсоор захижээ.

MINFO
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

БАЙГАА НЬ ЭРХ МЭДЭЛД ХАРЖ БАЙНА

Ерөнхийлөгчийн тамгыг баран бариултай болгоё

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

тэмдэглэснийг уншиж болно. Учир нь эртнээс нааш монголчууд төдийгүй Азийн орнууд арсланг манаач хэмээн бэлгэдэж үздэг байсан аж. Тэр ч битгий хэл арслан Бурхан багшид хаад, ноёдын орд, газар дэлхийд чөтгөр шулам, хулгай дээрэм оруулахгүй хамгаалж явъя гэж тагарагласан гэдэг домог ч бий. Тиймээс Азийн орнуудад хаан дээдсийн өргөө, алт мөнгөн сан хөмрөгүүдийн үүдэнд арслан чулуун хөшөө барьдаг аж. Манайд ч гэсэн ийм жишээ бас бий. Энэ утга агуулгыг ч эрдэмтэд нэлээд чухалчилж үздэг учраас Төрийн ордны арын цэцэрлэгт байгаа тамганы хөшөөг бүтээгч нь бидэнтэй ярилцаж байгаад баран бариултай бүтээсэн юм билээ. Тэгвэл одоо Үндсэн хуульд байгаа “арслан бариултай байна” гэдэг үгийг л өөрчлөөд, бар болгочиход болно. Зарим нэг нь хаадууд л баран бариултай тамга хэрэглэж байсан биз. Ерөнхийлөгч ямар хаан юм уу. Тэгээд ч манайх Ерөнхийлөгчийн засаглалтай орон биш гэх мэтээр шөвөлзөж магадгүй. Ерөнхийлөгчийн болд төмрөөр хийж, анар эрдэнэ чулуугаар чимэглэсэн нь олонтаа байна. Чингис хааны тамга нь гангаар сийлсэн баран бариултай хаш тамга байсныг ч эртний Хятад, Перс, Иран Ирак, Монголын түүхийн эх сурвалж бичгүүдээс харж болно. Үүний нэгэн жишээ нь Чингис хаанаас хаан тамгыг үе улируулан Их Юань гүрэн байгуулсан Хубилай хааны барьж байсан баран тамгыг нэр бүхий арав гаруй их хаад хашсаар байжээ” хэмээн түүхэнд

Мэдээж төрийн тамга тэдийг харьцах тэдэн см-ын хэмжээтэй, цул мөнгөөр, гар аргаар хийнэ. Бариул нь 0.8 см байна гэх мэтээр дэлгэрэнгүй бичсэн байдаг л даа, тэнд. Гэхдээ хамгийн гол алдаа нь арслангийн дүрстэй бариултай байна гэдэг үг гэдгийг өвгөн доктор сануулаад байгаа юм. Тэрбээр энэ талаар хэдэн жилийн өмнөөс л ярьж байгаа. Яагаад үүнийг өөрчлөх хэрэгтэй вэ гэхээр, Монголын түүхэнд манай хаад, ноёд баран бариултай тамга хэрэглэдэг байж. Тэгээд ч судар бичигт баран бариултай тамгатай, барсын арьсан хэвнэгтэй хэмээн бичиж үлдээсэн байдаг байна. Энэ нь Монголын хаадын тамганы бариул бар байсныг гэрчилж байгаа хэрэг. Нөгөө талаар түүхэн эх сурвалжуудад ч гэсэн хаад баран бариултай тамгатай байсныг бичиж үлдээсэн. “Ер нь монголчууд төр ёсны бэлгэдэлт зүйл хааны болоод төрийн тамга, хаан сэлэм зэргийг ширээсэн ган болд төмрөөр хийж, анар эрдэнэ чулуугаар чимэглэсэн нь олонтаа байна. Чингис хааны тамга нь гангаар сийлсэн баран бариултай хаш тамга байсныг ч эртний Хятад, Перс, Иран Ирак, Монголын түүхийн эх сурвалж бичгүүдээс харж болно. Үүний нэгэн жишээ нь Чингис хаанаас хаан тамгыг үе улируулан Их Юань гүрэн байгуулсан Хубилай хааны барьж байсан баран тамгыг нэр бүхий арав гаруй их хаад хашсаар байжээ” хэмээн түүхэнд

гарын үсэг цуглуулаад явж байгаа нь намын эв нэгдлийг бутаргах. Цаашлаад тодорхой эрх мэдэлд хүрэх гэсэн тэмцэл гэж харагдаж байгаа. Энэ хүмүүсийн үйлдлээс үүдээд намд шинэчлэл хэрэгтэй юм байна гэдэг нь ч харагдаж байна. Гэхдээ намын шинэчлэл гэдэг нэг, хоёр хүнийг сольсноор болчихдог зүйл биш. Системийн шинэчлэл хэрэгтэй байгаа юм.

Иргэдийн хурлын даргыг огцруулахаар МАН-ын бүлгийн 16 гишүүн гарын үсэг зурчихлаа. Цаашид энэ хүмүүстэй хариуцлага тооцох

гар хөлийн үсэг цуглуулаад яваад байгаа нь буруу. Яагаад бид бүлгийн хурал дээрээ нээлттэй ярилцаад, гараа өргөөд, олонхиороо асуудлаа шийдэж болохгүй байгаа юм. Удахгүй намын Бага хурал болох гэж байна. Намын тэргүүлэгчид хуралдана. Их хуралчхуралдана. Тэнд асуудлаа ярилцаад, олонхиороо шийдээд л явах ёстой. Тийм байтал наана нь ингэж сэм хуйвалдаж, гарын үсэг цуглуулж байгаа нь байж болохгүй асуудал. Аль аль шатандаа. Одоо Засгийн газрыг огцруулна гээд л гарын үсэг цуглуулаад байна л гэнэ. Ийм

Тэргүүлэгчид Удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг хэлэлцээд, түүнийхээ дагуу нийслэлийн Иргэдийн хурал болоод нам дотор орнож байгаа асуудалд чиглэл өгнө. Түүний дараа бүлэг хуралдана. Сэм хуйвалдсан гэж би яагаад хэлсэнэ одоо тайлбарлая. Жишээ нь, би Иргэдийн хурал дахь МАН-ын Бүлгийн дарга. Гэтэл гарын үсэг цуглуулаад байгаа бичгийг өнгөрсөн баасан гарагт өргөн барихад нь л харсан. Надаас асуугаад, гарын үсэг зурах уу гэж хэн ч хэлээгүй. Зарим төлөөлөгчдөөс сонсоход, намын Иргэдийн хурлыг хуралдуулья гэсэн бичиг байсан. Гэтэл өргөн барьсны дараа Хурлын даргаа огцруулья болчихсон байна гэж хэлсэн. Зарим нь хүчээр шахаж зуруулсан гэдэг ч асуудал яригдаж буй. Энэ бол байж болохгүй асуудал. Намыг хагалан бутаргах, Их хурал, Бага хурлаас өмнө хүчгүйдүүлэх гэсэн оролдлого. Бараг сөрөг хүчнээс “шидсэн чулуу” юм болов уу гэж харж байна.

УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж, МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан гэдэг нэр бүхий хүмүүс “60 тэрбумын бичлэг бол үнэн. Эвлүүлэгчид хамгаалж байна” гэх мэтээр ярьсан нь асуудлыг улам дэвэргэчихлээ?

“Мянга сонсоход нэг үз гэдэг. Нүд үнэнч, чих худал гэдэг үг ч бас бий. Одоо гараад байгаа зүйлүүдэд итгэхэд хэцүү болчихсон. Хууль хяналтын байгууллага эцэслэн тогтоогоогүй байхад хэн нэгэн хүнийг гэм буруутайд тооцогүй гээд Үндсэн хуульд заачихсан байгаа. Ц.Нямдорж гишүүн, намын Ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүтэй хүмүүс хэн нэгний үгээр явж, яригдаж байгаа асуудлууд үнэн юм байна гэж мэдэгдэж буйг би буруу гэж үзэж байна. Хамгийн наад захын жишээ ярья. Сарнай гээд эмэгтэй байгаа шүү дээ. Олон хүүхдийг асардаг. Тэр хүн миний л мэдэхийн энэ оны зургаа, долдугаар сарыг хүртэл баатрын дайтай нэр хүндтэй

байлаа. Гэтэл наймдугаар сард өнөөх эмэгтэйг чинь луйварчин энэ тэр гээд сошиалаар дүүрэн муу муухайг нь дуудаж байсан. Харин одоо эргээд сайн хүн гэгдээд л явж байна. Үүнтэй адил юу ч баталгаажуулахгүй байхад хүний нэр хүндэд халдаж, цаана нь гарах үр дагаварыг нь харалгүйгээр хийсвэр хөнгөн хандах нь буруу. Ийм мэдэгдлүүд хийж байгаа нь хариуцлагагүй үйлдэл гэж бодож байна.

“Энэ бүх асуудал намын Бага хурал, Их хурлаар нэг мөр шийдэгдэнэ л гэж харж байна уу?”

“Бид наана нь мянга яриад энэ асуудлыг шийдэх боломжгүй. Тийм болохоор хэтэрхий улстөржүүлж, ажил цалгардуулах хэрэггүй. Асуудлыг бид намын Бага хурал, Их хурлаараа шийднэ. Нийслэлийн намын тэргүүлэгчид хуралдана. Намын хороо бас хуралдах байх. Тэгж байж л асуудлаа шийднэ. Иргэдийн хурлын төлөөлөгчид асуудлыг шийдэх боломжгүй. Тийм байхад гарын үсэг зураагүй хэдийгээ “60 тэрбумын хамгаалагчид” гэж цоллож ч байх шиг. Энэ бол шахалтад оруулж байгаагийн нэг хэлбэр. Би өнгөрсөн дөрвөн жилд төрийн албанд ажилласан. Иргэдийн хуралд нэр дэвшихдээ албан тушаал наймцаалдаг, авлига өгдөг, авдаг, бусдыг хууль бусаар халдаг байдалтай тэмцэнэ гэж зорьсон. Тийм учраас энэ асуудлууд үнэн байгаад, албан тушаалд томилгогдохдоо мөнгө төгрөг өгч, авалцсан байвал үүний эсрэг би тэмцэнэ. Харин батлагдаагүй, эцэслэн нотлогдоогүй байхад бусдын нэр хүндэд халдаж болохгүй ээ. Монгол Улсын Ерөнхийлөгч хүртэл өөрөө АТГ-ын удирдлагуудыг дуудаад, олон нийтийн өмнө үүрэг өгсөн. Тэр хүмүүс нь ажлаа хийг. Бид ч өөрсдийнхөө ажлыг хийе. Энд мянга улстөржөөд байх хэрэггүй. Харин хуулийн байгууллага нь асуудлыг хурдан шийдээд өгөх хэрэгтэй байна. Түүний дараа нам хуулийн байна уу, ёс зүйн байна уу асуудлаа ярилцана.

...Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны хүрээнд Иргэдийн хурлын ээлжит бус хурлыг хуралдуулах хэмжээнд хүрээгүй. Дээрээс нь гарын үсгээ зураагүй МАН-ын төлөөлөгчид 60 тэрбумын хэрэгт холбогдоод байгаа хүмүүсийг өмгөөлж хамгаалж байна гэсэн мэдээллийг хэвлэлээр болон сошиалаар тарааж байна. Тийм юм байхгүй...

асуудал яригдах болов уу?

“Намын үндсэн дүрэмд заасан байдаг. Гишүүд намын эв нэгдлийг хамгаалах, намын нэр хүндийг гутаасан аливаа үйлдэл гаргахгүй байх. Намын нэрийн өмнөөс сонгогдож, томилогдсон албан тушаалтан хуулийг чандлан сахих, аливаа явцуу бүлэглэлийн нөлөөнд автахгүй байх ёстой гэж заасан байгаа. Эдгээрийг зөрчих юм бол намаас дэмжлэг үзүүлэхгүй гэж дүрэмд бий. Дүрмийн хүрээнд бид асуудлаа ярьж таарна. Намын Их хурал, Бага хурлаараа бид асуудлаа яриад, ардчиллын зарчмаар олонхиороо шийдээд явдаг. Гэтэл зарим хүмүүс “сэм хуйвалдана” гэдэг шиг дайдуур

байж болохгүй ээ. Тэр битгий хэл зарим төлөөлөгчийг хүчээр гарын үсэг зуруулахаар хоолой амыг нь боосон гэсэн яриа гарсан. Энэ бол байж болохгүй асуудал.

Танай намын зарим төлөөлөгч хэвлэлд ярилцлага өгөхдөө “Бид хуйвалдсан, сэмхэн гарын үсэг цуглуулсан юм байхгүй. Огцруулах бичиг өргөн барихаа эртнээс мэдэгдэж, гарын үсэг зурж эхэлсэн” хэмээн ярьсан байсан. Түүнээс гадна ойрын үед намын бүлэг хуралдах боломж байгаа юу?

“Энэ долоо хоногтоо нийслэлийн МАН-ын тэргүүлэгчид хуралдах байх. Тэндээс нэг шийдвэр гаргана.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



...Àì üäðàëä
ì °í òèéí ç;éë äÿæ
ààéäàãã;éòÿé
àäèè àæèè, àëàáí
òóøààè ì °í òèéí
àèø...

УИХ дахь МАН-ын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн
Д.Хаянхярваа

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ҮЙЛ ЯВДАЛ

**Ж.Бат-Эрдэнэ
жихиг дунд
үйлдвэрлэлийг
хөгжүүлэх санал
хүргүүлэв**

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнийг хүлээн авч уулзлаа. УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнэ “Жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх асуудлаар санал тавьж байсныхаа дагуу зарим аймаг орон нутагт ажиллалаа. Өрхийн үйлдвэрлэл байгуулах, ийм хөтөлбөр хэрэгжихийг хүлэсэн иргэд олон байна. Орон нутагт өрхийн үйлдвэрлэл хөгжих боломж, бололцоо бүрэн байна. Өрх чадамжтай, иргэн баян байвал улс орон хөгжиж байдаг. Монгол Ардын нам 2016 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “21:100” хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгасан. Энэ хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төрийн бодлогыг хандуулж, 2018 оны төсөвтэй уялдуулж өгнө үү гэсэн саналыг Ерөнхий сайд танд гардуулж байна” гэлээ. “21:100” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэлийг орон нутагтаа бий болгох чиглэлээр Засгийн газар тодорхой бодлогын арга хэмжээ авч ажиллаж байгаа. Бидний төлөвлөгөөнд таны санал чухал гэдэгт итгэлтэй байна. Энэ хүрээнд ажлын байр нэмэгдэж, иргэдээ ажил, орлоготой болгох боломжтой болно. Засгийн газар жижиг, дунд болон өрхийн үйлдвэрийг хөгжүүлэхэд гол бодлогоо чиглүүлж үйлдвэрлэгчдээ дэмжин ажиллаж байгаа. Бодлого боловсруулж ажил хэрэг болгоход УИХ-ын гишүүдийн санал чухал гэдгийг Ерөнхий сайд онцлолоо.

“ХЭЭРИЙН МАЛ ЭМНЭЛЭГ” үзүүлэх сургалт боллоо



Г.ЧИМЭГ

ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэнгийн санаачилгаар аймаг нийслэлийн ХХААГ, сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтнүүдэд салбарын бодлого зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг үр дүнтэй бодитой өрнүүлэхэд анхаарах, ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, туршлага солилцох зорилгоор бүсчилсэн сургалтыг энэ сарын 19-21-ний зохион байгуулахаар болсон. Энэ хүрээнд Төвийн бүсийн сургалтыг хооронд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд амжилттай зохион байгууллаа. Сургалт, зөвлөгөөнд ХХААХУ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга М.Мөнхбаясгалан, Бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Энх-Амар, ЖДҮХБХЗГ-ын дарга М.Дондогдорж, ХШҮЦАГ-ын дарга Д.Совд, Хуулийн хэлтсийн дарга Б.Батцэцэг болон албаны бусад төлөөлөл оролцлоо.

Төвийн бүсийн сургалтад нийслэл, Дундговь, Сэлэнгэ, Төв, Дархан аймгийн ХХААГ, сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн 200 гаруй мэргэжилтэн оролцов.

Сургалтын үйл ажиллагааг нээж, ХХААХУ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга үг хэллээ. Тэрбээр “ХХААХУ-ийн сайдын санаачилгаар ХХААХУ-ийн салбарын анхан дунд шатанд ажилладаг мэргэжилтнүүдэд зориулж бүсчилсэн сургалтыг зохион байгуулахаар болсон. Өнөөдөр гурав дахь сургалт нь амжилттай болж байна.

Бүсчлэн зохион байгуулагдаж буй сургалт зөвлөгөөнөөс та бүхэн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбар яамны бодлого чиглэл, төсөл хөтөлбөр, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг олон талын мэдээллийг нэг дор авах болно” гэдгийг онцлон хэлэв.

Сургалт, зөвлөгөөний үеэр малын гоц халдварт өвчний үеийн “Хээрийн мал эмнэлэг дэлгэх” үзүүлэх сургуулилт боллоо. Сургалтаар малын гоц халдварт өвчин гарсан үед анхан шатанд ямар арга хэмжээ авах, илрэх шинж тэмдэг,

хорио цээр тогтоосон бүс нутагт хэрхэн ажиллах зэргийг Онцгой байдлын Ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын газар, Сэлэнгэ аймгийн ХХААГ хамтран үзүүлсэн юм.

Мөн Сэлэнгэ аймгийн 17 сумын Мал эмнэлэг үржлийн тасагт мотоцикл гардуулан өгөв. Энэ нь анхан шатанд ажиллаж буй мэргэжилтнүүд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, салбарын бодлого, бүс нутгийн хөгжлийн зорилт, үйл ажиллагааг орон нутагт амжилттай хэрэгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулах юм.

OMEGA

Speedmaster
38 mm

Ω
OMEGA

OMEGA Boutique: Central Tower, Sukhbaatar Square, 2nd Floor, Tel: 9963-9494

УЛС ТӨР

ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД МОНГОЛ



Х.БАТТУЛГА: ОХУ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ гэж найдаж байна

амьдарч, хөгжиж чаддаг. Энэ бол монгол хүний онцлог юм. Өнөөдөр олон зуун гадны ажиллах хүч манай ажлын байрыг эзэлж, тэд манай орны хөгжилд оролцож байна. Үүнийг бид өөрчилнө. Өнөөгийнхөөс ялгаатай нь цаашид байгалийн баялгийн үр шимийг ард түмэндээ тэгш хүртээх болно. Сүүлийн 20 жилд байгалийн баялгийн лицензийг хэдхэн хүн ашиглаж, ашгийг нь тэд л хүртэж ирсэн. Ийм байдлаар улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн хувийн ашиг орлого нь өссөөр байна. Үр дүнд нь нэг талаас, Монголд ядуурал, ажилгүйдэл нэмэгдэж, нөгөө талаас, улс төрийн бүлэглэлүүд хөрөнгөжиж нөөц баялаг нь өсөх нөхцөл бүрдсэн. Энэ бол миний хамгийн гол сэдвийн нэг юм. Миний хувьд өөр нэг чухал чиглэл бол дэд бүтэц. Энэ салбарыг манай ард түмэн өөрсдөө бүтээж хөгжүүлэх ёстой. Энэ салбар Орос, Хятад гэсэн хоёр хөрштэйгээ дэд бүтцийн салбарт харилцах гол чиглэл байх ёстой. Далайд гарцгүй манай орны хувьд хөршүүдтэйгээ нягт хамтран ажиллах нь чухал юм.

-Орос, Монгол ойрын сайн хөршүүд. ОХУ-тай харилцаагаа хөгжүүлэх тухайд та хэр ач холбогдол өгч байгаа вэ?

-Манай хоёр орон олон зууны түүхтэй найрамдалт орнууд, хөршүүд явж ирсэн. Бид түүхийн баялаг замыг туулж, бие биеэ дэмжээр ирсэн. Сүүлийн жишээ гэхэд л Халхын голын тулалдааныг бид мартаж өсгүй. Үүнийг байнга дурсч байх ёстой гэж би боддог. Монгол Улс ОХУ-ын хил орчмын Холбооны субъектуудтай харилцаж, хамтран ажиллах нь хоёр орны хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Бүс нутгийн харилцаа хамтын ажиллагааг шинэ өндөрлөгт гаргах ёстой. Энэ нь чөлөөт худалдааны бүс байгуулах, Байгаль нууртай холбоотой асуудал, Эгийн гол дээр усан

цахилгаан станц барих төсөл зэрэгтэй холбоотой. Манай бүс нутгийн хооронд харилцан ойлголцох явдал дутмаг байгаа нь санал зөрөлдөх явдалд ч хүргэж мэдэх юм. Бидний харилцаа, ялангуяа зэвсэг техникийн 95 хувь нь ОХУ-д үйлдвэрлэгддэг тул батлан хамгаалах салбар эрчимтэй хөгжино гэдэгт найдаж байна.

-Таныхаар бол Орос-Монголын хамтынажиллагаа аль салбарт хөгжвөл илүү чухал гэж бодож байна?

-Өмнө хэлсэнчлэн хамтын ажиллагааны гол салбар бол нэгдүгээрт, батлан хамгаалах салбар. Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Б.Бат-Эрдэнэ саяхан ОХУ-ын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгутай уулзсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс ОХУ-ын Батлан хамгаалахын сайдад илгээлт явуулсан. Монголчууд Сергей Шойгуг тува гаралтай гэж мэддэг, түүнд маш сайн ханддаг. Хоёрдугаарт, хөдөө аж ахуйн салбар. ЗХУ-ын үед манай улс тус улсад үйлдвэрлэсэн ХАА-н техникийг маш өргөн хэрэглэдэг байлаа. Өнөөдөр ийм техник цөөрсөн учраас хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагаагаа бэхжүүлэх зайлшгүй шаардлага бий. Манай хоёр орон байгаль цаг уурын төстэй нөхцөлд оршдог. Бид бас монгол малын махыг Эрхүү мужид экспортлох талаар ярьж байгаа. Харамсалтай нь энэ асуудал ахиц муутай байна. Хамтын ажиллагааны бас нэг салбар бол дэд бүтэц, тээврийн салбарын хөгжил юм. УБТЗ бол Орос-Монголын хамтарсан хөтөлбөрүүдийг өөрчилсний дараа үлдэж хоцорсон ганц төсөл. Оросын талтай 50, 50 хувийн оролцоотой энэ төслийг өргөжүүлэхэд бид онцгой анхаарах болно. 2016 онд УИХ-ын сонгуулийн өмнө "Эрдэнэт" үйлдвэрийн Оросын талын эзэмшлийн 49 хувь нь зарагдсан. Энэ бол ноцтой асуудал. Ийм явдал УБТЗ дээр бүх гараасай гэж бид бодож байна. Уул

уурхайн хэд хэдэн лиценз эзэмшдэг "Монголросцветмет" компани гэж бий. Өнөөдөр асар их өртэй байгаа энэ компанийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд бид анхаарах хэрэгтэй байгаа юм.

-Монгол бол үзэсгэлэнт сайхан байгалиараа давтагдашгүй орон. Оросын жуулчдын тоог нэмэгдүүлэх талаар та юу гэж зөвлөмөөр байна?

-Аялал жуулчлал гэдэг чанартай үйлчилгээ, сайн удирдлага, зохицуулалт шаарддаг өвөрмөц салбар. Ирэх жил шинэ нисэх буудал нээнэ. Энэ бол аялал жуулчлалын салбарт, ялангуяа оросын жуулчдыг татахад том түлхэц байх болно. Оросын жуулчид өнөөдөр Монголд цөөн ирж байгаа. Үндсэндээ Сибирийн бүсээс л цөөн жуулчин автобусаар ирж амарч байна. Москва болон ОХУ-ын Европын хэсгийнхэн бол Турк, Европын орнууд руу л явж байгаа шүү дээ. Тэгээд ОХУ-ын Буриадын аяллын товчоодтой Япон, БНСУ-ын жуулчдыг Буриад, Монгол Улс, Өвөрмонголд, өөрөөр хэлбэл "гурван монгол"-оор аялуулдаг аялал жуулчлалын тойрог бий болгох талаар санал солилцсон. Хошигтний хөндийн нисэх буудал ашиглалтад орчихвол Москва, Санкт-Петербургээс ч жуулчид авах боломжтой. Түүнчлэн жуулчдын үйлчилгээний нөхцөлийг сайжруулахын төлөө ажиллаж байна.

-Та Владивостокт болох Дорнын эдийн засгийн форумд оролцохоор төлөвлөж байгаа юм байна. Энэ форумын хүрээнд ажил амжуулахаар төлөвлөж байгаа вэ?

-Энэ бол миний анхны гадаад айлчлал юм. Энэ форумын хүрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин болон Зүүн хойд Азийн орнуудын Төрийн тэргүүнүүдтэй уулзахаар төлөвлөж байна. Хөтөлбөрийг Монгол Улсын Гадаад харилцааны яам боловсруулж байгаа.

Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга ОХУ-ын мэдээллийн ТАСС агентлагийн сурвалжлагч Алексей Селищевийн тавьсан асуултад хариулж, ярилцсаныг бүрэн эхээр нь хүргэж байна.

их бий. **-Хүн бүр л улс орныхоо ирээдүйн төлөө сэтгэл зовж явдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд улсынхаа ирэх арван жилийг хэрхэн төсөөлж байна вэ?**

-Аль ч улсын Төрийн тэргүүнд улс орноо удаан хугацаанд хөгжүүлэх зорилгыг өөртөө тавьдаг шүү дээ. Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль их онцлогтой болсон. Монголын ард түмэн эдүгээ нүүрлээд байгаа эмх замбараагүй байдал, ядуурал, ажилгүйдлийг арилгаж өгөөч гэсэн хүсэл эрмэлзлээр намайг сонгосон. Миний хувьд Ерөнхийлөгчөөр сонгогдохоосоо өмнө хоёр том яаманд ажиллаж байсан тул ажлын багагүй туршлага

бий. Ойрын дөрвөн жилд эдийн засгийн том алхам, хөтөлбөрүүдийн эхлэлийг тавина. Түүнчлэн улс орны хөгжлийн гол үндэс болсон эдийн засгийн хүрээнд хийхээр төлөвлөсөн тодорхой зүйл байгаа. Бүрэн эрх өндөрлөх үед үр дүнг ярьж болно.

-Та уламжлалт ёс заншлыг өөрчлөлт шинэчлэлтэй хэрхэн хослуулах вэ?

-Аль ч улс орон хөгжлийн бодлогоо ард түмнийхээ олон зууны уламжлал, зан заншилд тулгуурласан байдаг. Монголчууд бол нүүдэлчин ард түмэн, миний биеэр ч нүүдэлчний цус гүйж л байгаа. Тиймээс бид нүүдэлчдийн уламжлал дээр тулгуурласан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Монголчууд бие даан

-Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгтэй ойргон нягтрах талаар томоохон алхмууд хийж, ялангуяа Азид идэвхтэй үүрэг гүйцэтгэхийг эрмэлзэж буй. Үүнийг та хэрхэн үнэлж, энэ чиглэлээр цаашид юу хийх ёстой гэж бодож байна вэ?

-Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрөөд дөнгөж сар гаруйхан хугацаа өнгөрч байна. Улс орныхоо гадаад бодлогын талаар надад бодож төлөвлөсөн олон санаа, төлөвлөсөн ажлууд бий. Монгол Улс газар нутгийн байршлын хувьд Ази тивд байдаг учраас Азийн бүх улс оронтой дипломат харилцаатай явж ирсэн. Гэхдээ бидэнд нэг онцлог бий. Энэ нь манай улс хоёр том гүрэн, тодруулбал, Орос, Хятадын дунд оршдог. БНХАУ-тай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай. Япон, Энэтхэгтэй ч мөн адил стратегийн түншлэлийн харилцаатай. БНСУ-тай ч иж бүрэн түншлэлийн харилцаагаа хөгжүүлж байна. Газар зүйн байрлалынхаа онцлогийг ашиглаж, гадаад харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө ажиллах болно. Манай улсын бас нэг онцлог бол Европын улсуудтай Оросоор хиллэдэг, Азийн орнуудтай бол Хятадаар хиллэдэг. Тиймээс нэн тэргүүнд хоёр хөршдөө айлчилж, эдийн засгийн харилцааг сайжруулах тал дээр бодит алхмуудыг хийнэ гэсэн бодолтой байгаа. Жишээ нь, гааль, худалдааны тариф дээр нэлээд өөрчлөлт хийнэ. Монгол Улс газрын баялаг ихтэй орон учраас боломжийн хэрээр нэмүү өртөг шингээж, технологийн хувьд шинэчлэх, дэлхий сонирхдог хоёр том зах зээл рүүгээ хандсан экспорт хийхийг зорих болно. Ерөнхийлөгчийн тангараг өргөснөөс хойш 35 хоног өнгөрч байна. Тодорхой хугацааны дараа тодорхой зорилтуудыг ярина. Бодож, төлөвлөсөн зүйл

ММINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

ТАТАХ
PLAY STORE
APP STORE

Дахиж харгахгүй Хаах

ДЭЛХИЙ

Корон судар шатаасан хүүг баривчилжээ

Пакистаны төв хэсгийн Пунжаб мужид Исламын шашны корон судар шатаасан гэх шалтгаанаар 18 настай Христын шашинт хүүг баривчилжээ. Энэ талаар өчигдөр албаныхан мэдээллээ. Орон нутгийн цагдаагийн газраас мэдээлснээр, хэрэг энэ сарын 12-ны шөнө гарсан байна.

Тухайн үед цагдаагийн газарт Христын шашинтай өсвөр насны хүү корон судар шатааж байна гэх гомдол ирсэн байна. Улмаар дуудлагын дагуу хэргийн газарт очиж, Асиф Массих гэх 18 настай хүүг баривчилжээ. Хэргийг цаашид шүүхэд шилжүүлэхээр төлөвлөж буй аж. Шүүхээр хүүг гэм буруутай гэж үзсэн тохиолдолд цаазаар авах ял ч оноож болзошгүй тухай "Франц пресс" мэдээлсэн байна. Сэжигтнийг цагдаа нар баривчлах үед 200 орчим Исламын шашинтнууд цугларч, хүүг яллахыг шаардаж байжээ. Пакистанд Исламын шашныг доромжилсон хэрэгт сэжиглэгдсэн хүмүүсийг бүлэглэн зодох тохиолдол ч гарч байсан юм. Энэ оны тавдугаар сард социал медиад цацагдсан бичлэгээс үүдэн хинди шашинтай нэгэн залууг Исламын шашныг доромжилсон хэмээн бүлэг этгээд цагдаагийн газар руу дайрч, үүний улмаас 10 настай хүүхэд нас барж, таван хүн гэмтэж байжээ.

АНУ-ын 10 усан цэрэг сураггүй боллоо

АНУ-ын сөнөөгч хөлөг онгоц Сингапурын эрэгт нефть тээвэрлэгч хөлөг онгоцтой мөргөлдсөний улмаас 10 усан цэрэг сураггүй болж, таван цэрэг гэмтэж бэрсэн гэж АНУ-ын тэнгисийн цэргийн хүчин мэдэгдлээ. "USS John McCain" хөлөг онгоц өчигдөр өглөө үүрээр Сингапурын зүүн хэсэгт боомтод зогсохоор явж байхдаа Либерийн далбаатай хөлөг онгоцтой мөргөлдсөн байна. Аврах болон эрэн хайх ажиллагаа ид өрнөж байна гэж албаны хүмүүс мэдэгдэв. Нефть тээвэрлэгч "Alnic MC" хөлөг онгоцны статус болон хөлгийн багийнхны талаар тодорхой мэдээлэл алга. Гэхдээ уг хөлөг онгоц нь "USS John McCain"-аас бараг гурав дахин хүнд буюу 30 мянган тонн жинтэй гэсэн мэдээлэл байна. Энэ нь сүүлийн хэдэн сарын дотор АНУ-ын тэнгисийн цэргийн хүчний хөлөг онгоц холбогдсон хоёр дахь "ноцгой" осол юм. Өнгөрсөн зургадугаар сард "USS Fitzgerald" хөлөг онгоц Японы Йокосука боомт хотын усанд чингэлэг ачаан хөлөг онгоцтой мөргөлдсөний улмаас Америкийн долоон усан цэрэг амиа алдсан билээ.



ПХЕНЬЯН: ГАЛ ДЭЭР ТОС НЭМЛЭЭ

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Үүнээс гадна энэ жилийн сургуулилын нэг онцлог нь НҮБ-ын гишүүн орнууд болох Их Британи, Австрали, Канад гэсэн долоон орны

...Харин Солонгосын хойгт БНСУ-АНУ-ын цэргийн хамтарсан сургуулилт эхэлсэн энэ үед Пхеньян ямар алхам хийх нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байна...

алба хаагчид оролцож байгаа аж. АНУ-ын цэргийн командлагч Харри Бинклей Харрис, Стратегийн командлалын тэргүүн, генерал Жон Хайтен нар ням гарагт БНСУ-д хүрэлцэн очсон бөгөөд сур-

гуулилыг биечлэн хянах юм байна. БНСУ-ын Ёнхан агентлагийн мэдээлснээр, цэргийн командлагч Харри Бинклей Харрис Сөүлд газардсаныхаа дараа тус улсын Батлан хамгаалахын сайд Сон Ян Мүтэй уулзжээ. Уулзалтын үеэр Харрис "АНУ БНСУ-ыг батлан хамгаална гэсэн амлалтаа биелүүлэхийн төлөө хатуу зогсоно. Мөргөлдөөн тэмцэл хэзээ ч гарч болзошгүй" хэмээж, БНАСАУ-ыг үүссэн нөхцөл байдалд буруутгасан байна.

Тэгвэл БНАСАУ-ын Хөдөлмөрчдийн намын "Нодон Синмун" сонинд АНУ болон Өмнөд Солонгосын цэргийн хамтарсан сургуулилт нь Умард Солонгосын эсрэг дайсагнасан үйлдэл үзүүлж буй хамгийн том илрэл гэж бичсэн байна.

Мөн АНУ, Умард Солонгосын талаас нэг бус удаа гаргаж байгаа мэдэгдлийг үл тоосон хэвээр байх тохиолдолд цөмийн асуудалтай холбоотой сэдэв хүрээгээ тэлэх алхмаа эхлүүлж, мөн энэ нь АНУ өөрийн улсын аюулгүй байдлын эсрэг үйлдэл үзүүлж байгаа хэрэг хэмээн мэдэгдэлдээ онцолсон байна.

Пхеньян өнгөрсөн жилийн хамтарсан цэргийн сургуулилын үеэр усан доогуур шумбагч хөлгөөс баллистик пуужин харвах туршилт хийж байсан юм. Түүнчлэн, сургуулилт дөнгөж дууссаны дараа буюу есдүгээр сарын 9-нд тав дахь удаагийн цөмийн туршилтаа хийж байсан удаатай.

Харин энэ жилийн тухайд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс

Хойд Солонгосын эсрэг авсан хориг арга хэмжээгээ чангатгасны дараа АНУ-ын шинэ Ерөнхийлөгч Доналд Трамп Пхеньяныг доромжилсонтой холбогдуулан цэргийн ерөнхий командлагч Ким Жон Ун "Хвасон-12" гэх дундын зайн тив алгасагч дөрвөн пуужингаа АНУ-ын Гуамын арал руу чиглүүлчихээд байгаа билээ. Гэхдээ сөргөлдөгч талууд хэн нь эхэлж өдөөн хатгасан алхам хийхийг хүлээж, байдлыг ажиглах болсноор үүссэн хурцадмал байдал түр хугацаанд намжаад байсан юм. Харин Солонгосын хойгт БНСУ-АНУ-ын цэргийн хамтарсан сургуулилт эхэлсэн энэ үед Пхеньян ямар алхам хийх нь дэлхий нийтийн анхаарлыг татаж байна.

Гэртээ жорлонгүй гэх шалтгаанаар салжээ

Энэтхэгийн баруун хойд этгээдийн Ражастан мужийн шүүх гэртээ жорлонгүй гэх шалтгаанаар гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн эмэгтэйн гомдлыг хэлэлцэн шийдвэрээ гаргажээ. Эхнэр нь гомдолдоо "Гэрийн гадна бие засахдаа заавал хол явах шаардлага гардаг. Түүнтэй гэрлэсэнээ хойнхи таван жил тэсвэрлэхэд бэрх байлаа" хэмээн дурьдсан байна. Тус мужийн ерөнхий шүүгч Ражендра Кумар Шарма "Энэ эмэгтэй гэртээ жорлонгүй учраас гадаа гарч бие засахын тулд харанхуй болохыг хүлээхээс өөр аргагүйд хүрдэг байна. Энэ нь бие бялдрын хувьд тэсвэрлэшгүй зүйл" гэдгийг онцолж байжээ. Мөн үргэлжлүүлэн "Залуучууд тамхи, согтууруулах ундаа болон гар утас худалдан авахад мөнгө хайрлахгүй зарцуулдаг атал гэр бүлийнхэндээ амьдрах таатай орчин нөхцөл бүрдүүлэх, тухайлбал зориулалтын ариун цэврийн өрөө барих гэж хичээл зүтгэл гаргахгүй байна. Ариун цэврийн байгууламж байхгүйн улмаас олон эмэгтэй хүссэн үедээ бие засаж чадахгүй,

гадаа бие засахын тулд харанхуй болохыг хүлээхээс өөр аргагүйд хүрч байна" гэж ярьсан байна. Гэрлэлтээ цуцлуулах өргөдөл гаргасан эмэгтэйн өмгөөлөгч "Франц пресс" агентлагт ярилцлага өгөхдөө "Энэтхэгийн хамгийн чухал эрүүл мэндийн асуудал болох гадаа жорлонгийн талаар ярих нь ичгэвтэр зүйл биш. Эмэгтэйчүүд бие засах гэж байгаад аливаа эрсдэлд өртөхгүй гэсэн баталгаагүй. Тиймээс шүүх шийдвэрээ гаргасан" гэж ярьжээ. Энэтхэгийн хуулиар гэр бүлийн хүчирхийлэлд байнга өртсөн, хүнд хэцүү амьдарч буй тохиолдолд ч салахын зөвшөөрдөг байна. НҮБ-ын Хүүхдийн сангаас мэдээлж буйгаар Энэтхэгийн хүн амын бараг тал хувь нь буюу 600 сая хүн гадаа бие засдаг аж. Энэтхэгийн хүн амын бараг 90 хувь нь гар утасны сүлжээнд холбогдсон байхад, 70 орчим хувь нь жорлонгийн асуудлаа шийджээ. Ерөнхий сайд Нарендра Модди 2019 он хүртэл бүх бус нутгийг жорлонжуулна гэдгээ амласан билээ.

Хамгийн хурдан галт тэрэг ирэх сараас үйлчилгээнд явна



Дэлхийн хамгийн хурдан галт тэрэг ирэх сараас Бээжин-Шанхай хотын хооронд албан ёсоор явж эхэлнэ. "Fuxing" буюу "Сэргэн мандалт" гэдэг энэ галт тэрэг нь хоорондоо 1318 км зайтай оршдог тус хоёр хотын хооронд есдүгээр сарын 21-нээс 350 км/ц-ийн хурдтайгаар зорчигч тээвэрлэж эхлэх ажээ. Энэ галт тэрэгний нэрийг тус улсын дарга Ши Жиньпин өгсөн байна. Одоогоор Хятадад явж буй хамгийн хурдан галт тэрэг нь

цагт 300 км туулдаг "Hexie" буюу "Эв найрамдал" гэдэг галт тэрэг гэнэ. Тус галт тэрэгний нэрийг Ху Жиньгао өгч байжээ. Хятадын хурдны галт тэрэг болон төмөр замын техник хэрэгслүүд нь Бээжингийн хувьд бусад улсад, ялангуяа "Бүс ба Зам" санаачилгад хамаарах улсуудад борлуулах гол бүтээгдэхүүнүүдийнх нь нэг болоод байгаа юм. Бээжин-Шанхайн хооронд "Сэргэн мандалт" хурдны галт тэрэгээр явахад нэг талдаа жирийн суудал 553 юань байх бол нэгдүгээр эерэглэлийн суудал нь 933 юань байна.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга /ЧД, 11 дүгээр хороо/-ын ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **НХААГ-17/0189**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй Цэцэрлэгийн барилга /ЧД, 11 дүгээр хороо/-ын ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн дотор** хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил /2015, 2016 он/-ийн борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байх.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил /2015, 2016/**

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **Сүүлийн 2 жилд /2015, 2016 он/ доод тал нь нэг удаа төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.**

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Тийм**

Зураг төсөл боловсруулах байгууллага нь: Барилга, хот байгуулалтын яамны:

-1.2.1.1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилгаархитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, ҮЗБТ)

-1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл

-1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг

төсөл (10 кВ хүртэл)

Дотор радио холбоо, галын болон бусад дохиоллын систем, дохиолол, мэдээллийн байгууламжийн зураг төсөл, хамгаалалтын систем, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологи, компьютер хангамжийн дотоод сүлжээ, гадна салбар шугам сүлжээний зураг төсөл

Орон сууц, олон нийт, үйлдвэрийн барилгын болон тоног төхөөрөмжийн хянах, хэмжих хэрэгсэл /КИП/, автоматикийн зураг төсөл -1.2.6. Техник, эдийн засгийн үндэслэл, барилгын төсөв

Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

Барилга, хот байгуулалтын яамны:

- 2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт

-2.1.2. Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээгдсэн барилгын угсралт, өргөтгөл, шинэчлэлийн ажил /1-5 давхар/

- 2.2.1. Барилгын дотор халаалт, салхивч, ус хангамж, ариутгах татуурын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт

- 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, Холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног төхөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт

Тендерийн хамт 15,380,000 /арван таван сая гурван зуун наян мянга/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендерт оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Хүчинтэй байх хугацаа: **2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийг дуустал хүчинтэй байна.**

Тендерийг **2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11 цаг 00 минутас** өмнө цахим системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байшлуудан тендерийг **2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11 цаг 30 минутад** Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот хурлын өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодны давуу эрх **тооцно.**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Салбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ЦАГ ҮЕ

МЭДЭЭЛЭЛ

НИЙТИЙН ТЭЭВРЭЭР ЗОРЧИХ ЦАХИМ КАРТ ШИНЭЭР АВАХ, СУНГУУЛАХ ОЮУТНУУДЫН ӨРГӨДЛИЙГ АВЧ ЭХЭЛЛЭЭ



Э.ТУУЛ

Хичээлийн шинэ жил эхэлж буйтай холбогду олон нутгаас Улаанбаатар хотыг зорин ирэх оюутнууд олон байгаа билээ. Тиймээс өчигдөр нийтийн тээвэрээр зорчих цахим картмын асуудлыг харууцдаг “Улаанбаатар смарт карт” ХХК-иас оюутны смарт карт олголт, сунгалтын талаар мэдээлэл хийлээ. Энэхүү хэвлэлийн хуралд нийслэлийн Боловсролын Газрын захиргааны хэлтсийн дарга Л.Буянтогтох, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын, хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Г.Ганзориг, “Улаанбаатар смарт карт” ХХК-ийн үйл ажиллагааны хэлтсийн дарга Ц.Түвшинжаргал нар оролцож мэдээлэл өгсөн юм.

Л.Буянтогтох: Шинээр элсэж байгаа оюутнууд энэ сарын 21–25–ны хооронд сургуульдаа өргөдлөө өгөх ёстой

Нийслэлийн Боловсролын Газрын захиргааны хэлтсийн дарга/

Их, дээд сургуульд шинээр элсэж байгаа оюутнууд наймдугаар сарын 21-25-ны хооронд сургуульдаа төлбөрийн цахим карт авах өргөдлөө өгөх ёстой. Энэ долоо хоногт багтааж, их дээд сургуулиуд оюутнуудынхаа нэгдсэн өргөдлийг нийслэлийн Боловсролын газарт ирүүлнэ. Манай газрын Төлбөрийн цахим карт хариуцсан мэргэжилтэн энэ сарын 28-30-ны өдрүүдэд картыг идэвхжүүлээд

сургуулиудад буцаан олгоно. Харин сургуулиуд тус картыг оюутнууддаа есдүгээр сарын 01-нээс олгож эхлэх ёстой. Нийтийн тээврийн төлбөрийн цахим картыг сунгах тухайд шинэ оюутнуудын захиалгатай адил хугацаатай. Харин уг картыг дахин олгох хугацаа есдүгээр 01-08-ны өдрүүдэд хийгдэнэ. Их, дээд сургуулиуд есдүгээр сарын 08-15-ны өдрүүдэд карт дахин захиалах хүсэлтийг нийслэлийн Боловсролын газарт ирүүлнэ. Энэхүү хүсэлтийг бид шалгаж үзээд есдүгээр сарын 15-21-ний өдрүүдэд цахим картыг дахин олгоно. Цахим картыг дахин олгох үйл ажиллагаа Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв болох Дунжингарав, Драгон, Мишээл дээр явагдахаас гадна Зургаан буудалд байрлах Оргил худалдааны төв, нийслэлийн Боловсролын газрын нэгдсэн төв дээр явагдана.

Г.Ганзориг: 13 мянга гаруй оюутанд төлбөрийн цахим карт олгоно

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын, хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга/

НХЭГ-аас 32 МСУТ, коллежийн 13 мянга гаруй оюутанд төлбөрийн цахим карт олгоно. Шинэ оюутнуудын цахим төлбөрийн картын захиалга болон дахин захиалах, сунгах хугацаа наймдугаар сарын 21-25-ны өдрүүдэд үргэлжилнэ. Ингээд карт олгогдох дараалал НБГ-ын ажилтай төстэй явагдана.

Ц.Түвшинжаргал: “Ub smart bus” нэртэй аппликэйшнээс автобусны чиглэлийн мэдээллийг авах боломжтой

Улаанбаатар смарт карт” ХХК-ийн үйл ажиллагааны хэлтсийн дарга/

Оюутнууд маань “Ub smart bus” нэртэй аппликэйшныг татаж аваад автобусны чиглэл болон карт цэнэглэх борлуулах цэгүүдийн мэдээллийг зэргийг авах боломжтой. Оюутны цахим карт сунгах ажил тодорхой цаг хугацаанд хийгддэг ажил учраас оюутнууд маань хугацаандаа багтаад сургалтын албандаа өргөдлөө өгөхийг хүсч байна.

“Багш нарын цалинг нэмэгдүүлэх” түр хорооноос өчигдөр ээлжит хэвлэлийн бага хурлаа хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга болон эцэг, эхчүүдэд уриалга гаргаснаа мэдэгдсэн юм. Багш нар цалингаа бүс нутгийн төвшинтэй ижил хэмжээтэй болгон нэмэгдүүлэх үндсэн шаардлагыг Засгийн газарт тавиад байгаа талаар бид өмнө нь мэдээлсэн. Тэгвэл энэ удаа Түр хорооны ажлын явцын талаар дэд зохицуулагч, Мэдээллийн

болон ерөнхий боловсролын сургуулийн 30 гаруй мянган багш нэгдэн, зохион байгуулалтад орж Монгол Улсын Засгийн Газарт цалинг нэмүүлэхэд чиглэсэн гурван зүйл бүхий шаардлага хүргүүлснийг Танд уламжлахын хамт дараах чиглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг, чиглэл өгөхийг уриалж байна. Үүнд, сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлага, үндсэн ажилтан нь багш

Багш нар төрийн өндөрлөгүүд болон эцэг, эхчүүдэд хандан уриалга гаргав

технологийн багш Б.Бат-Эрдэнэ “Манай түр хороо байгуулагдаад ес хоног өнгөрч байна. Энэ хугацаанд бид үйл ажиллагаагаа төлөвлөж, эхний ээлжинд Засгийн газарт гурван агуулга бүхий шаардлагыг хүргүүлсэн. Уг шаардлагын хариуг наймдугаар сарын 24-нд хүлээж авна. Хэрэв шаардлагыг биелүүлэхгүй бол тэмцлийн арга хэмжээ зохион байгуулна. Манай түр хороо аймаг, сум, дүүргүүдээр хуваагдан зохион байгуулалттай ажиллаж байна. Одоогоор манай түр хороонд нэгдэхээ бичгээр мэдэгдэж, гарын үсгээ цуглуулж өгсөн 4615 гишүүн бий. Үүнээс гадна бид н-мэйлээр болох олон нийтийн сайтаар өгсөн 11 мянга гаруй гарын үсэг байна. Багш нар өнөөдрөөс эхлээд сургалт, семинар гээд цуглаж эхэлж байгаа учраас цаашид энэ үйл ажиллагаа маань улам өргөжинө” гэв. Энэхүү ажилд нэгдсэн багш нар монгол хүний ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх, багш нарын цалингийн урамшууллын шаглалыг бүх багшид хүртээмжтэй болгох, цалингаа нэмэгдүүлэхийг шаардаж байгаагаа хэлж байсан юм. Түүнчлэн хамгийн өндөр цалинтай багш 820410 төгрөгийн цалин бодуулаад гар дээрээ 657134 төгрөг авдаг бол дөнгөж ажиллаж эхэлж байгаа багш нар 535000 төгрөгийн цалин аваад түүнээсээ 107 мянгыг нь татварт өгч, гар дээрээ 428 мянган төгрөг авдаг хэмээн хэлсэн юм. Тиймээс “Багш нарын цалинг нэмэгдүүлэх” түр хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгад хандан уриалга хүргүүлжээ. Тэд уриалгадаа “Багшийн цалинг нэмүүлэх зорилгын дор сургуулийн өмнөх боловсролын

болохыг харгалзан үзэж холбогдох төрийн захиргааны байгууллагуудад үйл ажиллагааг өртөгжүүлэх зарчимд үндэслэн багшийн үндсэн цалингийн доод хэмжээг бүс нутгийн жишигт хүргэж нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өртөгжүүлэх зарчимд үндэслэн багшийн цалин хөлсний шаглалыг шинээр бий болгож хэрэгжүүлэх, сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургууль нь эх оронч бүтээлч, чадвартай, харууцлагатай, ухамсартай, соёл иргэншилтэй ирээдүйн иргэдийг бэлтгэдэг тэргүүдэд, үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц салбар болохынх нь хувьд түүний удирдлагыг намын харьяалал, улс төрийн томилгооноос ангид байлгаж хамт олны санаид үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч томилдог байх”-ыг хүсчээ. Түүнчлэн эцэг, эхчүүдэд хандаж гаргасан уриалгадаа “Багш мэргэжил аль ч улсад нийгмийн хөгжилд оруулж буй үнэт хувь нэмэр, жингээрээ бусад мэргэжлээсээ их, тэргүүлэх, эх мэргэжил юм. Багшийг ийнхүү эрхэмлэн үздэг нь бас монгол түмний уламжлалт соёл, үнэт зүйл мөн. Гэвч багшийн талаар 1990 оноос хойш явуулж ирсэн үе үеийн сайдын увайгүй, харалган бодлогын үр дүнд багшийн ажлын үнэлэмж унасан, нэр хүнд доошилсон, багш ядуурсан, ядарсан. Тиймээс Монгол Улсыг хүний оюуны чадамжид тулгуурласан зөв хөгжилд хүргэхийн төлөөх их үйлсийн эхлэл юм. Иймд багшийн цалингаа нэмүүлэх энэ хөдөлгөөн, тэмцлийг эцэг, эхчүүд, хүүхэд залуучууд, татвар төлөгчид, нийт монголчууд зөвөөр тусган авч биднийг дэмжихийг уриалж байна” гэжээ.



Food and Agriculture Organization of the United Nations

АЖЛЫН ЗАР

No: АЗ-ССР/МОН/014/ЕС-АЗ

АЛБАН ТУШААЛ: Төслийн орон нутгийн зохицуулагч
Нийтэлсэн огноо: 2017-н оны 08-р сарын 15
Анкет авах сүүлийн огноо: 2017-н оны 08-р сарын 25

ТӨСЛИЙН НЭР/КОД: “Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх нь (SECiM)
Бүрэлдэхүүн хэсэг 2: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл GCP/MON/014/EC

БАЙРЛАЛ: СЭЛЭНГЭ АЙМАГ **ГЭРЭЭТ ХУГАЦАА:** 12 сар (сунгах боломжтой, туршилтын хугацаатай)

БАЙГУУЛЛАГА: НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага

замуудыг санал болгох

10. Төсөл хэрэгжиж буй бусад аймгууд болон аймгууд дахь төслийн Орон нутгийн зохицуулагч нартай үйл ажиллагаагаа уялдуулж, хамтран ажиллах

11. Төсөл амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг төслийн удирдлагатай хамтарч гүйцэтгэх, санаачлан хэрэгжүүлэх

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Бизнесийн удирдлага, эдийн засаг, маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Бизнес, эдийн засаг, маркетингтай холбоотой ур чадваруудыг маш сайн эзэмшсэн байх
- Хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн байгууллагад бизнес, эдийн засгийн салбарт хамгийн багадаа 5 жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн хувьд болон багаар ажиллах чадвартай, уян хатан байх, үүнд мэргэжлийн ёс зүй, харилцааны өндөр соёлтой, хүлээцтэй, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй, хувийн зохион байгуулалт сайтай, төлөвлөгөө боловсруулах, ажил үүргийг зөв хуваарилах, цагийг үр ашигтай ашиглаж чаддаг байх
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй,
- Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэг, ур чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг (Word, Excel, Access, PowerPoint, Outlook гэх мэт) мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй хүмүүс НҮБ-ын ХХААБ-ын анкетыг (FAO Personal Profile Form (PPF)) <http://www.fao.org/employment/irecruitment-access/en/сайтнаас> татан авч бөглөн холбогдох тодорхойлолтуудын хамт secim-registry@fao.org хаяг руу илгээж, эх хувийг Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) бичиг хэрэгт бүртгүүлэн хүлээлгэж өгнө үү.

Холбогдох бичиг баримтуудаа аймгийн ЗДТГ-г хүргүүлсэн бол энэ талаар secim-registry@fao.org хаягаар давхар мэдэгдэнэ.

Хэрэв Улаанбаатар хотод байгаа бол мөн өөрийн биеэр ХХААХҮЯ-ны 9А байрны 103 тоот төслийн төв нэгжид авчирч өгнө үү.

Холбоо барих: 08:30-17:30 цагийн хооронд 70150078 дугаарын утсаар

холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авч болно.

Урьдчилсан сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилгогчдыг ажлын ярилцлагад урих болно.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Бизнесийн удирдлага, эдийн засаг, маркетингийн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Бизнес, эдийн засаг, маркетингтай холбоотой ур чадваруудыг маш сайн эзэмшсэн байх
- Хүнс, хөдөө аж ахуй, бизнесийн байгууллагад бизнес, эдийн засгийн салбарт хамгийн багадаа 5 жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн хувьд болон багаар ажиллах чадвартай, уян хатан байх, үүнд мэргэжлийн ёс зүй, харилцааны өндөр соёлтой, хүлээцтэй, шинийг санаачлагч, бүтээлч сэтгэлгээтэй, хувийн зохион байгуулалт сайтай, төлөвлөгөө боловсруулах, ажил үүргийг зөв хуваарилах, цагийг үр ашигтай ашиглаж чаддаг байх
- Англи хэлний дунд түвшний мэдлэгтэй,
- Монгол хэлний бичгийн болон ярианы өндөр мэдлэг, ур чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний программуудыг (Word, Excel, Access, PowerPoint, Outlook гэх мэт) мэргэжлийн түвшинд эзэмшсэн бай

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ

Сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлтэй хүмүүс НҮБ-ын ХХААБ-ын анкетыг (FAO Personal Profile Form (PPF)) <http://www.fao.org/employment/irecruitment-access/en/сайтнаас> татан авч бөглөн холбогдох тодорхойлолтуудын хамт secim-registry@fao.org хаяг руу илгээж, эх хувийг Сэлэнгэ аймгийн Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) бичиг хэрэгт бүртгүүлэн хүлээлгэж өгнө үү.

Холбогдох бичиг баримтуудаа аймгийн ЗДТГ-г хүргүүлсэн бол энэ талаар secim-registry@fao.org хаягаар давхар мэдэгдэнэ.

Хэрэв Улаанбаатар хотод байгаа бол мөн өөрийн биеэр ХХААХҮЯ-ны 9А байрны 103 тоот төслийн төв нэгжид авчирч өгнө үү.

Холбоо барих: 08:30-17:30 цагийн хооронд 70150078 дугаарын утсаар

Урьдчилсан сонгон шалгаруулалтанд тэнцсэн ажил горилгогчдыг ажлын ярилцлагад урих болно.

ЗАВСАРЛАГА

Улаанбаатарт:



Маргааш

Өдөр +14
Шөнө +6

Нөгөөдөр



Өдөр +15
Шөнө +6

Өдрийн зурхай

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

Наран ургах, шингэх:

06.01-19.51



Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх зэрэг үйлд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсоод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Бидэнд тохиолдсон



Хүндхэн хөгтэй явдлууд

Ins Tinct

Ах маань гэрт байсан хөх томруулдаг тосоор орой бүр нүүрээ цэвэрлэдэг байсныг сая л мэдлээ. Даанч нүүр нь хавагнаад байсан юм. ха ха ха

ОДДЫН ЦАГ

ТОМ ХОЛЛАНД: Доналд Гловерын тайзны нэр Чайлдиш Гамбино байсныг сүүлд мэрсэн

Орчуулсан: Б.ДАВААХҮҮ

Энэ оны БАФТА-аас өсөх ирээдүйтэй жүжигчин шагналыг хүртсэн Том Холланд "Spider-Man: Homecoming" киноны гол дүрийг бүтээсэн билээ. Тус кино өнгөрөгч долдугаар сард дэлхийн кино театруудын дэлгэцнээ нээлтээ хийж, тэр даруйдаа хит уран бүтээл болж чадсан юм. Киног найруулагч Жон Уоттс найруулж, Роберт Дауни Жунior, Майкл Китон нар тогложээ. "Spider-Man: Homecoming" кино "Captain America: Civil War"

киноны дараах үйл явдлаар өрнөх бөгөөд Питер Паркер гэдэг жирийн нэгэн ахлах сургуулийн сурагч супер баатар болон хувирдаг билээ. Тэрбээр гэлт хэрэгтэй тэтгэхийн зэрэгцээ Нью-Йорк хотыг авардаг. Хүүг амжилттай супер баатар болоход нь Тони Старк тусладаг. Гол дүрийн жүжигчин Том Холланд эдүгээ 21 настай. Гэсэн ч энэ онд тэрбээр гурван ч дэлгэцийн бүтээлд ажилласан юм. Ингээд түүний найруулагч Жон Уоттсын халт "cinematoday.jp" сайтад өгсөн ярилцлагыг орчуулан хүргэе.



"Spider-Man: Homecoming" кинонд "Captain America: Civil War" киноны Питер Паркерын өөрийгөө бичсэн бичлэгийг ашигласан байна лээ. Бичлэг хийхэд хөгжилтэй байв уу?

-Том Холланд: Найруулагчийн хэлэх үгийг сонсомооргүй байсан болохоор гоё байсан.

Жон Уоттс: Миний хувьд ч гэсэн амар байсан. Түүнд камер өгөөд, хаалгаа хаачихсан. Харин дараа нь хийсэн бичлэгийг нь үзсэн л дээ.

-Анхнаасаа л тэр бичлэгээр киноны үзэгдлийг эхлүүлэх санаатай байжээ?

Уоттс: Тийм ээ. Миний эхний санаануудын нэг нь энэ байсан. Томын инстаграмм хуудастаа нийтэлсэн үсэрч буй бичлэгүүдийг нь үзээд "Энэ шүү дээ. Питер Паркер ч гэсэн яг ийм хөдөлгөөн хийх ёстой" гэж бодсон юм. /инээв/

-Киноны ойр орчимд нь өндөр барилга байхгүй. Тиймээс хүн аалз дүүжлэгдэж, үсэрч чадахгүй байгаа тэр

үзэгдэл их сонирхолтой санагдсан?

Том: Миний ч гэсэн дуртай хэсэг. Энэ удаагийн ярилцлагаараа дамжуулж, "Spider-Man: Homecoming" кино ямар онцгой бүтээл болохыг хэлмээр байна. Кинонд зөвхөн хүн аалз Манхэттенд амьдарч буй тухай өгүүлээгүй. Бидний өнөөдрийг хүртэл харж, төсөөлж ирсэн хүн аалзаас огт өөр байдлаар харуулж чадсанаараа онцлог болсон. Үүнийг Жон ч сайн гаргаж ирсэн. Тэр үзэгдэл яах аргагүй өнөөдрийг хүртэлх бидний харснаас өөр дүр байгаа. Хаанаас ч зүүгдэж, дүүжлэгдэж чадахгүй, бугуйнаасаа аалзны шүлс гаргаж, үсэрч чадахгүй. Тэр үзэгдлийн зураг авалт үнэхээр хөгжилтэй байсан шүү. Өндөр барилга байхгүй ч гэсэн түүнийг хүн аалз гэдгийг нь товойлгон харуулснаараа маш бүтээлч байж чадсан.

Уоттс: Энэ санааг дээр үеийн комиксоос авсан юм. Марвелын 237 дахь дугаар байх аа.

-Том хошин шогийн мэдрэмж сайтай юм билээ?

Том: Аав минь инээдмийн жүжигчин байсан. Алиа хошин зан миний цусанд байдаг юм болов уу. Гэхдээ олон гайхалтай санаанууд зохилоос л урган гарч байсан. Зохиол сайн учраас түүнийг сонирхолтой байдлаар үзүүлэн жүжиглэхэд хялбар байлаа. Хүн аалзыг олон сонирхолтой газруудад аваачсан болохоор зохиол дахь инээдмийн үзэгдэл аандаа л санаанаас урган гарч байсан. Би өмнө нь бүжигчнээр ажилладаг байсан. Тэр үеийн хөдөлгөөнүүд дүрээ бүтээхэд

минь тусалсан. Энэ бол зохиол сайн байсны л ач.

Уоттс: Том, аливаа зүйлийг цагийг нь олж хийхдээ сайн юм билээ. Инээдэмтэй хэсгийг яг цагийг нь олж, харуулж чадаж байсан.

Том: Баярлалаа. Тэр бол яах аргагүй эцгээсээ өвлөсөн авьяас байх. Оройн хоолны ширээний ард эцгийнхээ дуулах сонирхолтой яриаг нь сонсч өссөн болохоор тэр юм болов уу.

-Зураг авалтын үеийн уур амьсгалын талаар яриач?

Уоттс: Үнэхээр ноцтой байсан. /инээв/

Том: Кристофер Ноланы кино шиг... /инээв/

Уоттс: Бас чимээ аниргүй. Хэн ч авиа гаргаж чадахгүй.

Том: /инээв/

Уоттс: Наргиан шүү. Зүгээр л хөгжилтэй байх гэсэн юм. Аль болох бүгдийг нь тохь тухтай байлгахыг л хичээлээ. Эрэгтэй жүжигчдийн харилцаа ч таатай байв. Кино багт Оскар хүртэж

байсан жүжигчнээс эхлээд өмнө нь ямар ч кинонд тоглож байгаагүй шинэ жүжигчин хүртэлх янз бүрийн хүн багтсан. Тиймээс аль болох хүн бүрт л тав тухтай байхыг бодсон.

-Доналд Гловертэй хамтарч ажиллах ямар байв?

Том: Гайхалтай байсан. Энэ киноны бас нэг сонин зүйл нь түүний тайзны нэр Чайлдиш Гамбино байсныг огт мэдээгүй байсан явдал. Зураг авалт дууссаны дараа л мэдсэн. Чайлдиш Гамбиногийн дуунуудыг нь олон сонсч байсан. Гэхдээ уран бүтээлчийг нь нэг ч удаа харж байгаагүй юм. Тэгээд хайрлаж, хүндэлж явдаг уран бүтээлчтэйгээ уран бүтээл, дуу хөгжмийнх нь талаар нэг ч удаа ярилцаж чадаагүйдээ жаахан харамсан.

-Дараагийнх нь ангийг хийх бодол байна уу?

Уоттс: Тийм ээ, санаа бол маш их байна. Гэхдээ ярих боломжгүй.

ДУУЛГАХ СОНИН

Ц.Оюунчимэг Европын аварга боллоо

Швед улсад болсон хүндийн өргөлтийн Европын аварга шалгаруулах тэмцээнд Ц.Оюунчимэг түрүүлж, дээд амжилтыг шинэчиллээ. Түүний өрсөлдсөн эмэгтэйчүүдийн +75 кг-ийн жинд 14 туйванч оролцжээ. Алдарт Б.Түвдэндорж аваргын төрсөн дүүгийнх нь охин тэрбээр нэлээд хожуу буюу 49 настайдаа хүндийн өргөлтөөр хичээллэж эхэлсэн. Эдүгээ 55 настай Ц.Оюунчимэг дэлхийн цомын дөрвөн алт, дэлхийн наадам болон ДАШТ-ий хошой алт, мөнгө, гран при ангиллын тэмцээний дөрвөн алт, таван хүрэл медальтай. Мөн дэлхийн дээд амжилтыг 10, Ази тивийнхийг 15 удаа шинэчлээд байна.

Цагдаагийн олимпод оролцсон тамирчид эх орондоо ирлээ

Дэлхийн Цагдаагийн олимпод амжилттай оролцсон тамирчин, алба хаагчид өчигдөр үүрийн 04:00 цагт эх орондоо ирлээ. АНУ-ын Лос-Анжелос хотноо энэ сарын 7-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн цагдаагийн спортын наадамд Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Ч.Болдбаатарар ахлуулсан 25 офицер, ахлагчийн бүрэлдэхүүнтэй Монгол Улсын Цагдаагийн байгууллагын баг тамирчид спортын найман төрөлд өрсөлдсөн юм.

Тамирчид 14 алт, 12 мөнгө, долоон хүрэл нийт 33 медаль хүртэж, монгол цагдаагийн сүр хүч, бэлтгэл, авхаалж самбаа, тэсвэр тэвчээрийг дэлхийн төвшинд харуулсан. Ганзага дүүрэн ирсэн баг тамирчдыг ЦЕГ-ын удирдлагууд хүлээн авч, хүндэтгэл үзүүлэв.

ТЭНГИС

КИНО ТЕАТР

8 / 18 - 21

ҮЗВЭРИЙН ХУВААРЬ

10:30 12:30 14:30 15:20 16:30 18:30 20:10	10:50 12:20 14:30 16:40 18:55 20:30 21:10 23:20 Vip 13:45 22:25	10:45 12:30 17:26 20:25 22:45	10:35 13:25
	10:35 13:00 14:55 19:05 21:05 Vip 16:00 18:00	17:45 23:05	16:50 23:00 Vip 11:30 20:05

ШИНЭ

ШИЛДЭГ КОНТЕНТИЙГ ТҮГЭЭГЧ ҮНДЭСНИЙ КОМПАНИ

ТӨСӨӨЛЛӨВС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...